

СЭДЭВ: XVIII – XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЫН СОЁЛ НЭМЭЛТ УНШИХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

XVII зууны сүүлчээс XX зууны эхэнд монголчууд хэдийгээр Манж Чин улсын эрхшээл нөлөөнд байсан боловч үндэсний соёл, хэл, бичиг үсэг, зан заншлыг хадгалсаар байсан билээ. Манжийн үеийн Монголын соёлын онцлог нь нийгмийн оюун санааны амьдралд буддын шашны нөлөө нэвт шингэсний зэрэгцээ Монголын уламжлалт гэрийн сургуулиас гадна Манжийн албаны сургууль шашны дацан сургуулиуд байгуулагдсан явдал юм. Манжийн үед Монгол газар байгуулагдсан албаны сургууль нь цөөн тоотой бөгөөд сургалтын чанар зарим талаар муу байсны зэрэгцээ засаг захиргааны нэгжид ажиллах албан хаагч, бичээч, түшмэл бэлтгэх зорилготой байсан юм.

Монголд буддын шашин ихээхэн эрч далайцтай дэлгэрч байсан үед нийгмийн оюун санааны амьдралд шашны сургуулиуд чухал үүрэг гүйцэтгэж байв. Буддын шашны дацан сургууль энэ үеийн Монголчуудын сургууль, боловсролын хэрэгт зонхилж байсан юм. Шашны сургалтын тогтолцоо нь анхан шат ба дээд шат гэсэн анги бөгөөд анхан шатны сургуулиар 5-7 насны хөвгүүд лам багш нарын дэргэд шавилан сууна. Монголчууд Манж Чин улсын бүрэлдэхүүнд захирагдаж байсан түүхэн өвөрмөц нөхцөлд төвөд, хятад, манж үндэстний хэл соёлын нөлөө тэдгээрийн дунд хүчтэй болж улмаар монголчуудын гадаад хэлний мэдлэг эрс нэмэгдэж зохиол бүтээлээ төвөд, манж, хятад хэлээр туурвих буюу эдгээр хэлнээс монгол хэд орчуулга хийх явдал ч урьд урьдаас илүү газар авч байжээ.

Монголчуудын дунд эртний Энэтхэг, Төвөдийн гаралтай эмнэлэг нэлээд дэлгэрч, ардын эмнэлгийн байр суурь багасаж, эмнэлэг нь бүхэлдээ лам эмч нарын гарт оржээ.

Зураг 1. Сургуулийн төрөл хэлбэр



Манжийн эрхшээлийн үед монголчууд эх түүхээ умартаж, мартсангүй, харин ч аль болох судлах ажлыг хийж байсан нь тэр цагийн монголын соёлын нэгэн тэмдэглүүштэй үзэгдэл юм. XVII-XIX зуунд монголын түүхчид *Шар тууж*, *Лувсанданзаны Алтан товч*, *Саган сэцэний Эрдэнийн эрхи*, *Жамбын Асрагч нэртнийн түүх*, *Ширээт гүүш Дармагийн Алтан хүрдэн мянган хигээст хэмээх бичиг*, *Рашинпунцагийн Болор эрх* г.м гэх мэт зохиолуудыг бичжээ.

Тухайн үед Монголын үндэсний нэгдэл, төр ёсыг сэргээх гэсэн үзэл санаа хүчтэй болж, түүх судалгааны агуулга, сэдэв өргөжиж, түүх бичлэгийн арга барил сайжран, хэрэглэх сурвалж бичгүүдийн нэр тоо ч олширшээ.